

Бичигчээр М. Шиндэр, Шиндэр М. Шиндэр / Бичигчээр



**МОНГОЛЫН ГАЗРЫН ЗУРАГ,  
ГАЗРЫН НЭР СУДЛАЛ**



ISBN 978-99973-0-702-6



9 789997 307026

**МОНГОЛЫН ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН  
ТОКИОГИЙН ГАДААД СУДЛАЛЫН ИХ СУРГУУЛЬ  
МУИС-ИЙН МОНГОЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН  
БСШУ-НЫ ЯАМНЫ СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ  
МОНГОЛЫН ГАЗАР НУТГИЙН НЭР СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГ**

# **МОНГОЛЫН ГАЗРЫН ЗУРАГ, ГАЗРЫН НЭР СУДЛАЛ**

**Хариуцан эрхэлж хэвлүүлсэн:**

**С.ЧУЛУУН (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)**

**Э.РАВДАН (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)**

**Х.ФУТАКИ (Токиогийн ГСИС)**

**А.КАМИМУРА (Токиогийн ГСИС)**

**Улаанбаатар, 2015 он**

DDC  
526  
M-692

**Хариуцан эрхэлж хэвлүүлсэн**

**ЧУЛУУН С. (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)**  
**РАВДАН Э. (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)**  
**ФУТАКИ Х. (Токиогийн ГСИС)**  
**КАМИМУРА А. (Токиогийн ГСИС)**

**Эхийг хэвлэлд бэлтгэж хянасан:**

**АМАРЗАЯА Г. (Ховд их сургууль)**  
**БАТСҮРЭН Ч. (Хүмүүнлэгийн ухааны их сургууль)**  
**БАТДОРЖ Т. (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)**  
**ОЮУНСҮРЭН Ц. (Монгол улсын их сургууль)**  
**УРАНЦЭЦЭГ Б. (Монгол улсын их сургууль)**  
**ЭНХЖАРГАЛ П. (Монгол улсын их сургууль)**

“Монголын газрын зураг, газрын нэр судлал” энэхүү товхимол өмнө нь Токиогийн Гадаад судлалын их сургууль, МУИС-ийн Нэр судлалын төвөөс хамтран 2011 оны 8-р сард Улаанбаатар хотод зохион байгуулсан анхны *“International Academic Workshop: Tradition of Manuscript Maps in Mongolia under Qing Rule and the Bogd Khaan (Cartography and Onomastics)”* бага хурлын илтгэлүүдийг эмхтгэн 2012 онд хэвлүүлсэн *“Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд”* (Эмхтгэсэн Х.Футаки, А.Камимүра, Э.Равдан, Л.Чулуунбаатар, Улаанбаатар, 2012, 136 тал) дэвтрийн, удаах хурлын илтгэлүүдийг эмхтгэсэн хоёр дахь дэвтэр нь болой. Сүүлчийн эл хурлыг 2014 оны 8-р сарын сүүлчээр Улаанбаатар хотноо ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн (захирал нь д-р С.Чулуун), Токиогийн Гадаад судлалын их сургууль (проф. Х.Футаки, д-р А.Камимүра), БСШУ-ны Яамны Соёлын өвийн төв (захирал нь д-р Г.Энхбат), МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн (захирал нь проф. Ж.Бат-Ирээдүй), Монголын газар нутгийн нэр судлалын нийгэмлэг (тэргүүн нь проф. Э.Равдан) хамтран зохион байгуулсан болно. Эл дэвтэрт хуралд оролцсон Монгол, ОХУ, Япон, БНХАУ, Польш улсаас нийт 30-аад судлаачийн илтгэлийг өгүүлэл хэлбэрээр хэвлэн нийтлэв. Эмхтгэлд орсон өгүүлүүд нь Монголын эрт, эдүгээгийн түүх, соёлын өвийг судлагч хүн бүрт чухал олон баримтыг агуулсан болно.

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Д.Оюун  
Цаасны хэмжээ: 205x290 1/8  
Хэвлэлийн хуудас: 33

“Адмон принт” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв. 2015 он

ISBN 978-99973-0-702-6

## ОРШИЛ

Монгол орны эрт, эдүгээгийн газрын зураг, газрын нэр судлалын асуудлаар МУИС-ийн ГХСС-ийн Нэр судлалын төвийн захирлаар ажиллаж байхдаа миний бие өмнө нь эрдэм шинжилгээний төслийн хүрээнд хамтран ажиллаж байсан Токиогийн Гадаад судлалын их сургуулийн проф. Х.Футаки, д-р А.Камимүра нартай 2010 онд Токио хотноо учирч дээрх сэдвээр олон улсын “*International Academic Workshop: Tradition of Manuscript Maps in Mongolia under Qing Rule and the Bogd Khaan (Cartography and Onomastics)*” бага хурал 2011 оны 8-р сард Улаанбаатар хотод зохион байгуулахаар ярилцаж тохирсон бөлгөө. Уг хурал төлөвлөсөн ёсоор амжилттай болж Монгол, Япон, БНХАУ-ын нийт 10 гаруй судлаачийн илтгэлийг хэлэлцэж 2012 онд дээрх илтгэл болон бусад зарим судлаачийн өгүүллийг эмхтгэн “*Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд*” (Эмхтгэсэн Х.Футаки, А.Камимүра, Э.Равдан, Л.Чулуунбаатар, Улаанбаатар, 2012, 136 тал) товхимолыг нийтийн хүртээл болгон хэвлэсэн болно.

Бидний дээрх эхлэлийг Монгол улсын эрдэм шинжилгээний байгууллагууд, тухайлбал ШУА-ийн Түүхийн хүрээлэн (захирал нь д-р С.Чулуун), БСШУ-ны Яамны Соёлын өвийн төв (захирал нь д-р Г.Энхбат), МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн (захирал нь проф. Ж.Бат-Ирээдүй), Монпар компани (захирал нь д-р М.Саандар), Улсын үндэсний төв номын сан (захирал нь А.Нансалмаа), Монголын газар нутгийн нэр судлалын нийгэмлэг (тэргүүн нь проф. Э.Равдан), хувь олон хүн болон гадаадын цөөнгүй судлаач, тухайлбал: Унгарын нэрт монголч эрдэмтэн М.Татар, Польшийн О.Т.Молчанова, БНХАУ-ын Уйгар Шинжааны ӨЗО-ны эрдэмтэн До Мөнх, Б.Батжаргал, Японы судлаач Иноэ О. зэрэг цөөнгүй судлаач санхүү болон бусад талаар дэмжсэн тул уг сэдвээр олон улсын бага хурлыг бид 2014 оны 8-р сарын сүүлчээр Улаанбаатар хотноо хоёр дахь удаагаа зарлан хуралдуулав. Уг хуралд Монгол, Япон, БНХАУ, Польш улсаас нийт 30-аад судлаачийн илтгэлийг 2 өдрийн турш хэлэлцэж шүүв. Хурлын эцсийн өдөр хуралд оролцогчдыг Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн проф. Го. Акимын санаачлагаар Монголын үндэсний төв номын сангийн Монгол орны газрын зургийн өвөөр тус номын сангийн ажилтнууд үзэсгэлэн зохион байгуулж түүндээ урьсан нь гойд сонин, чухал арга хэмжээ боллоо. Уг хурлын материалаар бидний энэхүү “Монгол газрын зураг, газрын нэр судлал” эмхтгэлийг Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн (захирал нь д-р С.Чулуун), Токиогийн Гадаад судлалын их сургууль (проф. Х.Футаки) болон бусад судлаач нар санхүүжүүлж хэвлүүлэв.

Энэхүү товхимолын эхийг хэвлэлд бэлдэхдээ дараах шаардлагыг гүйцэлдүүлэхийг эрхэмд үзсэн болно. Үүнд, юуны өмнө зохиогчоос илэрхийлсэн үзэл санаа, бодлыг хүндэтгэн үзэх үүднээс өгүүллүүдэд утгын аливаа засвар, оруулгыг хийгээгүй болно. Харин үг үсгийн илт эндүүрэл, найруулгын зарим гажуудлыг залруулсан болохоо илтгэе. Нөгөөтэйгүүр, бид уг бага хурал дээр хэлэлцэж тохирсны дагуу илтгэлийг илтгэлийн хэлбэрээр бус зохих ишлэл, номзүйн хамт өгүүллийн хэлбэрт хөрвүүлэн бидэнд ирүүлэхийг зохиогчдод санал болгосон бөлгөө. Эл шаардлага нь аливаа бүтээлийн утга агуулгатай шууд холбоотой тул бид энэ талын засвар, оруулга хийгээгүйг эрхэм уншигч Та өөрөө үзэж болгоогоорой. Харин эх бэлтгэгчдийн зүгээс бид монгол, оросоор бичсэн олонх өгүүлэлд англи, англиар ирсэн бүтээлд монголоор утгын товчлол хадаж өгөв. Энд аливаа алдаа эндүүрэл гарсан байхыг үгүйсгэхгүй. Биднийг өршөөгөөрэй.

МТ-ын 300-гаад оны дунд үеэс эхлэн хоёр ч удаа Ази, Европын олон улс орныг эрхшээлдээ оруулан барьж байсан эртний хийгээд дундад эртний монголчуудын ул мөр өдгөө газрын зураг, түүнд туссан, тусаагүй нэрэнд мөнхжин бидний түүх-соёлын маргашгүй, марташгүй үгээр бүтээсэн хөшөө дурсгал, биет бус өв хөрөнгө болон дэлхийн

олон оронд үлджээ.<sup>1</sup> Энэхүү үүх түүх, соёлоо аливаа улс төр, гадаад бусад хүчин зүйлийн нөлөөлөлгүйгээр, зөвхөн үнэнийг удирдлага болгон судлан тогтоохыг эрхэмлэх болсон нь бидний амьдран буй эл түүхэн цаг хугацааны нэгэн таатай үе мөчлөг мөнөөс мөн. Тиймээс ч судалгааны эл чиг хандлага, сэдэв зөвхөн түүхчид төдийгүй, бусад олон сав ухаан, юуны өмнө хэл шинжээч, хүн судлаач, газарзүйчдийн анхаарлыг зүй ёсоор татаж байгаагийн илрэл нь дээр өгүүлсэн эрдэм шинжилгээний хоёр бага хуралд оролцсон хүний тоо хийгээд хэлэлцүүлсэн илтгэлүүдийн агуулга өргөжин тэлсэн явдал хэмээн үзүүштэй. Үүнтэй холбон Олон улсын монголч эрдэмтдийн холбоо (ерөнхийлөгч нь академич Д.Төмөртоогоо) монголч эрдэмтдийн ирэх оны хурлаас эхлэн “Монголын газрын зураг, газрын нэр судлал”-ыг бие даасан салбар хуралдаан болгохыг зөвшөөрөөд байгааг тэмдэглэхэд нэн таатай байна.

Эцэст нь тус бага хурлыг зохион байгуулах хийгээд хурлын илтгэлүүдийн эмхтгэлийг хэвлүүлэхэд санхүү болоод олон талын бусад тус дэмжлэг хүргэсэн дээр тоочсон болон тоочоогүй гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, сургууль, хувь хүмүүст хурал зохион байгуулсан нөхдөө би бээр төлөөлөн гүн талархал дэвшүүлж байна. Та бүгдийн маань сайн сэтгэлийн үр улам улам арвитах болтугай!

Монголын газар нутгийн нэр судлалын нийгэмлэгийн  
тэргүүн, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм  
шинжилгээний ажилтан Шинжлэх ухааны доктор,  
профессор *Өшгөг Энхбаярын РАВДАН*

Арван долоодугаар жарны Модон хонин жилийн  
Зуны адаг сарын Харагчин хонь сарын 21-ний өдөр тэрлэв.

---

<sup>1</sup> Түүний нотолгоо нь танай юм шүү хэмээн тогтоож өгсөн Европ хийгээд Азийн улс орнуудын олон судлаачийн бүтээлийг МУИС-ийн Нэр судлалын төвөөс 2005, 2006, 2013 онуудад тус тус эмхтгэн хэвлэсэн “*Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр*” (Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э.Равдан) гурван дэвтэр бэлхнээ нотолно буй за.

ГАРЧИГ

<b>Оршил</b> .....	3
<b>Монгол улсаас оролцсон:</b>	
Аким Г. “Эргүнэгун”-ы домог нь үнэн түүх бус уу? .....	7
Амарзаяа Г. Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн онцлог .....	14
Бадрал С. Газар дэлхийн зураг зүйн бүтээлүүд болон монголчуудын уламжлалт зураглалын ойлголт .....	24
Бат-Ирээдүй Ж. Орчин үеийн Монголын уран зохиол дахь газар усны нэрийн судалгааны асуудалд .....	40
Батсүрэн Ч. Монголын газар нутгийн нэр нүүдэлчний соёлтой холбогдох нь .....	46
Баттулга Ц. Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн хувьсал .....	49
Гэрэлбадрах Ж. Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутгийн нэгэн зургийн судалгаа .....	55
Гэрэлмаа Г. “Говь” хэмээх нэрийн тухай .....	65
Пүрэвжав Э. Монгол газар усны нэрийг зөв бичих асуудалд .....	185
Равдан Э. Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэрийн түүх-соёлын улбаа .....	191
Саандар М. Эртний газрын зургаар монголчуудын мөрийг мөшгөхүй .....	199
Түмэндэмбэрэл Т. Монгол улсын уулын газарзүйн байршил ба нэршил .....	207
Урангуя Ж., Пунсалдулам Б. Монголд Хаант Оросын консулын газар байгуулах үед зохиосон хүрээний газрын зургийн тухай өгүүлэхүй .....	210
Чулуун С. Оросын элч нарын XVII зууны тэмдэглэл дэх зарим газар усны нэрийн тухай товч мэдээ .....	221
Шагдарсүрэн Ц. Монгол газрын зургийн зарим шинэ олдвор хийгээд зурагт холбогдох бас бус зүйлийн тухайд .....	227
Энхбат Г., Нарантуяа Д. Музейн цуглуулга дахь газрын зургийн төрөл зүйл нь түүх, соёлын дурсгал болох нь .....	242
Энхжаргал П. “Улаан” нэр оролцсон газарзүйн биетийн нэрийг монгол-япон хэлнээ дүйлгэн үзэх нь .....	258
<b>ОХУ-аас оролцсон:</b>	
Зориктуев Б.Р. О некоторых закономерностях образования и функционирования этнонимов .....	70
Золтоева О.Ф. <i>Mongolian Landscape terms (Water Landscape terms)</i> .....	76
<b>Польш улсаас оролцсон:</b>	
Molchanova O.T. <i>Toponyms with Mongolian tribal names in the Territory of Altai, Russian Federation</i> .....	121
<b>БНХАУ-аас оролцсон:</b>	
Батжаргал Б. Зүүнгарын газрын зураг дахь Тэгш голын урсгал дагуу газар усны нэр .....	32
Мөнхөө До. Чин төрийн үеийн Тарвагатайн харъяат харуулын байгуулалт ба улирал хувьслын тухай .....	138
Мөнхөө До. Баруун хязгаарын эртний түүх, газар зүйн сурвалж хийгээд Монгол газрын нэрийн судлал .....	150
<b>Япон улсаас оролцсон:</b>	
INOUE Osamu, L. Altanzaya A Consideration on 清代乾隆期科布多疆域图 <i>Shindai Kenryuu-ki Kobudo Kyouiki-zu (The Frontier-Area Map of Hovd in Qianlong Era of Qing Dynasty)</i> .....	80
КАМИМУРА Акира Алтай урианхайн долоон хошууны газрын зургийн тухай .....	100

1. Аким Г. (Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн)  
Natagin@gmail.com
2. Акира Камимура (Токиогийн Гадаад судлалын их сургууль)  
kamimura.akira@tufs.ac.jp
3. Алтанзаяа Л. (Монголын боловсролын их сургууль)  
altan\_zaya@yahoo.com
4. Амарзаяа Г. (Ховд их сургууль)  
amarzaya2000@yahoo.com
5. Бадрал С. (Монгол улсын Соёл Урлагийн их сургууль)  
davana\_82@yahoo.com
6. Батжаргал Б. (БНХАУ, ШУӨЗО)  
martashiugoi@gmail.com
7. Бат-Ирээдүй Ж. (Монгол улсын их сургууль)  
iregedui@gmail.com
8. Батсүрэн Ч. (Хүмүүнлэгийн ухааны их сургууль)  
nom-ekhe@mongolian.mn
9. Баттулга Ц. (Монгол улсын их сургууль)  
ch\_tusgalt@yahoo.com
10. Гэрэлбадрах Ж. (Монголын Боловсролын их сургууль)  
gerelbadrakhdj@gmail.com
11. Гэрэлмаа Г. (ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн)  
g\_mgl2003@yahoo.com
12. Зориктуев Б. (ОХУ-ын ШУА - Буриадын салбар)  
enhe\_z@mail.ru
13. Золтоева О.Ф. (Буриадын их сургууль)  
zoph2004@yahoo.com
14. Молчанова О. (БНПУ, Щецинский их сургууль)  
molchan@univ.szczecin.pl
15. Мөнхөө До. (БНХАУ, ШУӨЗО)  
yuufumwp@sina.com
16. Нарантуяа Д. (Монголын Соёлын өвийн төв)  
cch\_fund@monheritage.mn
17. Пүрэвжав Э. (ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн)  
Purvee\_9@yahoo.com
18. Равдан Э. (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)  
ravdan2000@yahoo.com
19. Саандар М. (МонМэп ХХК)  
msaandar@monmap.mn
20. Түмэндэмбэрэл Т. (МУИС)
21. Урангуа Ж. (Монгол улсын их сургууль)  
uranguaakhereid@gmail.com
22. Хироши Футаки (Токиогийн Гадаад судлалын их сургууль)  
hfutaki@tufs.ac.jp
23. Чулуун С. (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)  
samchuluun@gmail.com
24. Шагдарсүрэн Ц. (Улаанбаатар их сургууль)  
shandastu@yahoo.com
25. Энхжаргал П. (Монгол улсын их сургууль)  
kouma79@yahoo.com
26. Энхбат Г. (Монголын Соёлын өвийн төв)  
enkhbat\_cch@yahoo.com
27. Inoue Osamu (Япон улс, Шиманэ-н их сургууль)  
os-inoue@u-shimane.ac.jp